



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 4/320

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2019 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819 922

Аймгийн Засаг даргын 2019 оны 19 дүгээр сарын
13-ны өдрийн 1/132 дугаар захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	"Ачлал-Оргил" ХХК	"Ачлал" хувийн эмнэлэг	Эмэгтэйчүүд, хүүхдийн өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ- 15/10/1010	5 жил	2019-07-28 2024-07-28
2	"Арвин Онги Фарм" ХХК	"Хүслэн" эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ- 17/10/1040	3 жил	2019-09-13 2022-09-13
3	"Монос Дундговь" ХХК	"Монос дундговь" эмийн сан	1-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ- 17/10/1041	3 жил	2019-09-13 2022-09-13